

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭСЦИЙН ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Шийдвэ- рийн дэс, дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц биелэлт	Хариуцах хэлтэс	Үнэлгэ э	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ							
1	1	2023.07.07	Нийгмийн даатгалын багц хууль	Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хэлэлцэн баталсан Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх, иргэд даатгуулагчдад сурталчлах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг томоохон зах худалдаа үйлчилгээний төвүүдэд 2 удаа, “Нээлттэй мэдээллийн сар” аяны хүрээнд 9,10,11 дүгээр саруудад төр хувийн хэвшлийн байгууллагуудад сургалт мэдээллийн цагийг зохион байгуулсан. 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Баянгол дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 400 гаруй ажил олгогчдыг хамруулсан “Ажил олгогчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан.	ЗХХ		
Хэсгийн дундаж хувь							
ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ							
2	№416	2023.11.29 Дугаар 416	Журам шинэчлэн батлах тухай	Шинээр тэтгэвэр тогтоолгож буй даатгуулагчдад ажилласан жилийг журмын дагуу тооцож тайлант хугацаанд шинээр: - Өндөр нас-1744 - Тахир дутуу-327	ТТХ		

				- Тэжээгчээ алдсаны-124 - Цэргийн тэтгэвэр-65 Нийт 2260 тэтгэврийг тогтоон цаг хугацаанд нь олгосон байна.			
3	№ 422	2023.11.29	Журам батлах тухай	Даатгуулагчийн сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардалд 26 хүний 7,086.19 мянган төгрөг, -ХЧТНөхөн сэргээх зардалд 1 хүний 1,210.0 мянган төгрөгийн зарлагыг цаг тухай бүрд нь олгосон байна.	ТТХ		
4	№ 438	2023.12.13	Журам батлах тухай	Тайлант хугацаанд ХЧАлдалтын тэтгэмж: Давхардсан тоогоор 11,613 даатгуулагчийн нийт 4,955,411,396.00 төгрөгийн тэтгэмжийг бодож цаг хугацаанд нь олгосон байна. Жирэмсэн болон амаржсаны: 3981 даатгуулагчийн мэдээллийн баазад оруулан нийт 14,566,216,619.40 төгрөгийн тэтгэмжийг бодож олгосон байна. Оршуулгын тэтгэмжид: 821 даатгуулагчид 1,642,000,000 төгрөгийн тэтгэмжийг хуулийн хугацаанд нь олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн: 4172 даатгуулагчийн материалыг анхан шатанд хүлээн авч хяналт шалгалтын улсын байцаагч нар шалгуулж нийт 18,109,544.6 сая төгрөг бодож олгох хуваарийн хамт сангийн нягтланд хүлээлгэн өгсөн байна	ТТХ		
5	№ 439	2023.12.13	Журам батлах тухай	Тайлант хугацаанд: Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас - Хөдөлмөрийн чадвар түр алдсан 103 даатгуулагчдад 243,388.04 төгрөгийн тэтгэмж олгож, - Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний сувиллын зардлын 26 даатгуулагчид 7,086.19 төгрөг, - Нөхөн сэргээх зардал 1 даатгуулагчид 1,210.000 төгрөг олгон ажилласан байна. ҮОМШӨ-ний Хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэрт 155 даатгуулагчийн 1,683,27.35 төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 26 даатгуулагчийн 287,078.07 төгрөг буюу нийтдээ 1,963,662,387.0 мян төгрөгийн тэтгэвэр олгосон байна.	ТТХ		

6	№ 450	2023.12.20	Журам батлах тухай	Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хүрээнд нийт 35,911 тэтгэвэр авагч нарт нийт 332,604,175,29 төгрөгийн тэтгэврийг олгосон байна. Тайлант хугацаанд шинээр: • Өндөр нас - 1744 • Тахир дутуу - 327 • Тэжээгчээ алдсаны - 124 • Цэргийн тэтгэвэр - 65 Шинээр нийт 2260 тэтгэврийг тогтоон цаг хугацаанд нь олгосон байна. 1800 гаруй тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоосон байна.	ТТХ		
7	№469	2023.12.27 Дугаар 469	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм болон Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрмийг газрын нийт байцаагч ажилтнуудад танилцуулах сургалтыг зохион байгуулан, бүртгэл хөтлөн гарын үсэг зуруулж ажилласан.	ЗХХ		
8	№471	2023.12.27 Дугаар 471	Жагсаалт, журам батлах тухай	2024 оны 01 дүгээр сараас эхлэн ажил олгогч нийгмийн даатгалын төлөлтийн тайланг даатгуулагч бүрээр ажил мэргэжлийн индексээр гарган сар бүр нийгмийн даатгалын төлөлтийн тайланг ирүүлж байна. Ажил олгогчдын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд заавар, зөвлөгөө өгч ажилласан.	ХОХ		
9	№10	2024.01.10 Дугаар 10	Итгэлцүүр тогтоох тухай	Тайлант хугацаанд шинээр: • Өндөр нас - 1744 • Тахир дутуу - 327 • Тэжээгчээ алдсаны - 124 • Цэргийн тэтгэвэр - 65 Шинээр нийт 2260 тэтгэврийг тогтоон цаг хугацаанд нь олгосон байна.	ТТХ		
10	№ 84	2024.02.28	Жагсаалт шинэчлэн батлах тухай	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 3 дугаар	ЗХХ		

				хавсралтыг үндэслэн Төрийн үйлчилгээний албан тушаалын зарим ажилтнууд буюу архивын ажилтан, үйл ажиллагааны нягтлан бодогч, бичиг хэрэг, дотоод хяналтын ажилтнуудын цалингийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн олгосон.			
11	№ 128	2024.03.27	Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3, 11 дүгээр хавсралтуудыг тус тус үндэслэн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус газрын байцаагч, ажилтнуудын цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн тогтоож олгосон.	ЗХХ		
12	№ 196	2024.05.08	Цахим системийн талаар авах арга хэмжээний тухай	Тус газрын хүний нөөцийн үндсэн болон цалин хөлсний мэдээллүүд, шилжилт хөдөлгөөнийг МУ-ын Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим систем, байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох ЭЙБЛ, Нийслэлийн захиргааны байгууллагуудын UB ERP цахим систем, Нийгмийн даатгалын салбарын GREEN ERP системүүдэд тухай бүр оруулж байцаагч, ажилтнуудын албан хэрэг хөтлөх, цалин хөлс авах, хянах боломжуудыг ханган ажиллаж байна.	ЗХХ		
13	№ 15	2024.04.17	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	Байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг жилийн эцсийн байдлаар www.Shilendans.gov.mn сайтад улирал тус бүрээр нийт 56 мэдээллийг ил тод болгон ажилласан. Мөн www.shilen.gov.mn мэдээллийн сайттай холбон 2 дугаар улирлын 5 бүлгийн 48 үзүүлэлтийг байршуулан 85,7 хувийн үнэлгээ авсан бөгөөд 4 дүгээр улирлын 5 бүлгийн 48 үзүүлэлт бүхий мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.	СБХ		
14	№ 75	2024.09.11	Аргачлал батлах тухай	Хугацаа болоогүй	ТТХэлтэс		
15	№362	2023.09.26 Дугаар 362	Дүрэм батлах тухай	Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл нь 7 удаагийн хурал зохион байгуулсан. Нийт 21 даатгуулагчийн өргөдөл хүсэлт, 2 ажил олгогчийн хүсэлтийг хүлээн авсан. Үүнээс 7 өргөдөл хурлаар оруулахад материал хангалтгүй буцаасан. Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамааруулан тэтгэвэр тогтоолгох хүсэлт өгсөн 7 даатгуулагчийн өргөдлийг хүлээн авч маргаан хянан шийдвэрлэх салбар	МХШЗөвлөл		

				зөвлөлийн хурлаар хэлэлцэн хөдөлмөрийн хүнд нөхцөлийг тогтоон шийдвэрлэсэн. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр нөхөн олгуулах 1 хүсэлтийг хүлээн авч 2 сарын тэтгэврийг нөхөн олгуулсан байна. Мөн маргаан хянан шийдвэрлэх хурлаар 6 даатгуулагчийн өргөдлийг хэлэлцээд Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарахгүй тул тэтгэвэр тогтоолгох боломжгүй гэж шийдвэрлэсэн байна.			
16	№ 109	2024.10.02	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын даргаас 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03/2139 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г хэрэгжүүлж ажиллах журмыг хэлтсийн дарга нар болон нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангаж, албан хаагч, албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг сахих, манлайлал үзүүлэн ажиллахыг үүрэг болгон нэгдсэн байдлаар ёс зүйн дэд хорооноос сургалтыг зохион байгуулан, зөвлөмж гарган ажиллаж байна.	Ёс зүйн дэд хороо		
Хэсгийн дундаж хувь							
ГУРАВ. САЙДЫН ТУШААЛ							
17	A/177, A/433	2023.12.07 A/177, A/433	Журам маягтын загвар батлах тухай	Монгол улсын засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн A/177, A/433 тоот хамтарсан тушаалыг үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 09-ний байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдалт болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийг цаг алдалгүй хянаж, иргэн даатгуулагчид хүргэж байна.	ТТХ		
18	A/441, A/192	2023.12.15 A/441, A/192	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн A/441, A/192 тоот хамтарсан тушаал үндэслэн 2024 оны 12 сарын 09-ны өдрийн байдлаар ЭММЗ нь иргэн/даатгуулагч/-ийг байлцуулан 44 удаа хуралдан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, сунгаж цуцалж шийдвэрлэснээс 561 иргэнд шинээр тогтоож, 2378 иргэний	ТТХ		

				хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 346 иргэнийг цуцалж, шилжиж явсан 9 иргэн, шилжиж ирсэн 25 иргэн, нас барсан 4 иргэн байна. ЭММЗ-ын мэдээллийн сангийн мэдээлэлд дотоод хяналт хийсэн. Тэтгэврийн байцаагч нартай хамтарч хөдөлмөрийн чадвар алдсан иргэд биеийн байдал сайжирсан эмчийн хяналтын хугацаа дууссан, сунгуулахгүй хянуулахгүй хаяж явсан, нас баралт бүртгэгдээгүй иргэдийг бүртгэлээс хасаж нэмэлтээр 2 удаа хуралдаж цэгцлэлт хийлээ.			
19	№А/87	2024.04.23 А/87	Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журмын дагуу батлагдсан хавсралтад дурдсан нөхцөлөөр тэтгэвэр тогтоох, А/87 тоот тушаалын хавсралтад нэмэгдэж орсон нөхцөлийн жагсаалтыг танилцаж хэрэгжүүлж байна.	ТТХ		
20	№А/22 1	2023.12.28 А/221	Жагсаалт, журам батлах тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журмын дагуу батлагдсан хавсралтад дурдсан нөхцөлөөр тэтгэвэр тогтоох ажлыг хийж хэрэгжүүлж ажиллаж байна.	ТТХ		
21	№А/20 2	2023.12.25 А/202	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход итгэлцүүрийг хэрэглэн ажиллаж байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/202 дугаар тушаалаар баталсан “Итгэлцүүр хэрэглэх журам”-ыг өндөр насны тэтгэвэр, цэргийн байнгын тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоохдоо үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар шимтгэлээ нөхөн төлсөн тохиолдолд итгэлцүүр хэрэглэх журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	ТТХ		

22	№А/200	2023.12.25 А/200	Журам гэрээний загвар батлах тухай	“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, сайн дураар даатгуулагчдад дагаж мөрдөх журам, гэрээний загвар батлах тухай Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайдын А/200 тушаалд заасан арга хэмжээнүүдийг тус тус авч хэрэгжүүлж ажиллаж байна. Гэрээний шаардлага: Сайн дурын даатгуулагч тухайн сарын шимтгэлээ сар дотор багтаан аль ч өдөр төлөх боломжтой ба хэрэв сар дамнуулан хугацаа хоцроож төлөлт хийсэн тохиолдолд гэрээнд заасан шимтгэл төлөх үнийн дүнгийн 0,3 хувиар тооцож, нэмэгдүүлсэн хоногоор алданги давхар төлөх тухай байцаагч анх гэрээ байгуулах үед даатгуулагчид сайтар тайлбарлаж, гэрээний үнийн дүн болон хугацааг даатгуулагчийн хүсэлтийг харгалзан 1-12 сарын хугацаанд цахим гэрээ байгуулан ажиллав. Шимтгэл сар дамнуулан төлсөн 550-600 сайн дурын даатгуулагчийн 12,510,258 мянган төгрөгийг алдангид төвлөрүүлэв. Мөн сайн дурын гэрээний хугацаа 2023.12.31-нд дууссан, даатгуулагч шимтгэлээ 2024 оны 01 дүгээр сард дамнуулан төлсөн 60-80 даатгуулагчийн шимтгэлийг 2024.03.19-ний 04/534 зөвлөмжийн дагуу алданги тооцон нөхөн бичилт хийж ажилласан. Уулзалт: Сайн дурын зөвлөгөө мэдээлэл авахаар ирсэн 3800-4000 иргэд даатгуулагчидтай тухай бүрд нь асуудлыг нь шийдвэрлэж, гомдол саналгүй ажиллах тал дээр анхаарч байна. Мөн Нийгмийн даатгалын үйлчилгээ цахим болсонтой холбоотой portal.ndaatgal.mn, гар утасны цахим аппликейшний талаарх мэдээллийг иргэдэд танилцуулж ажиллав. “Callpro” үйлчилгээгээр даатгуулагчдын утасны дуудлагыг хүлээн авч, дуудлага алдахгүй байх, алдсан дуудлагад эргэж холбогдож эргэх холбоотой ажиллахыг зорьж байна.	ХОХ		
23	№А/199	2023.12.25 А/199	Журам батлах тухай	“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилан журамд заасан арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Албан шаардлага: Тухайн сарын шимтгэлээ сар дамнуулан урсгал авлага үүсгээд байгаа байгууллагуудын удирдлага болон нягтлан бодогчдод урсгал авлага үүсгэхгүй байх тал дээр анхааруулж ажиллаж байна. 90 хүртэл хоногийн	ХОХ		

				насжилттай 17,717.65 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 397 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээр 109 байгууллагын 3,643.68 сая төгрөг барагдуулан ажилласан. Уулзалт: Нийгмийн даатгалын шимтгэлийн 11,208.39 төгрөгийн өртэй 144 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 32 байгууллагын 2,241.27 сая төгрөгийн өр авлагыг барагдуулж ажилласан байна. Данс хаасан: Шимтгэлийн авлага барагдуулахаар арилжааны банкуудад мэдэгдэл хүргүүлснээр 52,362.72 сая төгрөгийн өртэй нийт 4218 ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоож 1198 байгууллагын 18,716.50 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. Авлага барагдуулахаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 7 хоног бүр тогтмол удирдлагад танилцуулга хийж ажиллаж байна. Шүүхэд шилжүүлсэн: Шүүхэд шилжүүлж нэхэмжлэл үүссэн нийт 57 ажил олгогчийн 8,424.6 сая төгрөгийг шүүхэд нэхэмжилснээс 9 ажил олгогчийн бүрэн буюу хэсэгчлэн барагдаж, 1,404.20 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. НШШГГ-ын БТБГазарт шилжүүлсэн: НШШГГ-ын Банкны төлбөр барагдлуулах газарт шилжүүлсэн нийт 49 ажил олгогчийн 2,890.0 сая төгрөгийн өр үүссэнийг Банкны төлбөр барагдуулах газарт шилжүүлснээр 91.10 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна.			
24	№/А13 7	2023.10.06 А/137	Журам батлах тухай	Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/29 дүгээр тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг 5-10 хувиар нэмэгдүүлж, 31 байцаагчийн зэргийн нэмэгдлийг ХНУМТ цахим программд шинэчлэн оруулсан.	ЗХХ		
25	№/А13 6	2023.10.05 А/136	Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил мэргэжлийн жишиг цалин батлах тухай	МУ-н Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/136 тоот тушаалыг үндэслэн Тэтгэвэр тогтоолгох, үндэсний ажил мэргэжлийн жишиг цалинг баталсны дагуу иргэд даатгуулагчдын өргөдөл хүсэлтийн дагуу дундаж цалин байхгүй тэтгэвэр тогтоолгосон иргэдэд тус журмыг баримтлан хэрэгжүүлж байна.	ТТХ		

26	№/143 , A/376	2023.10.26 A/143, A/376	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын тушаал	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас журмын дагуу 1 даатгуулагчид 1200000 төгрөгийн протезын үнийг олгосон байна.	ТТХ		
27	№ A/44, A/140	2024.03.06 A/44, A/140	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал Маягтын загвар, аргачлал батлах тухай	Тус газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал дугаар A/44, A/40 тоот маягтын загвар аргачлалтай танилцан, программд өөрчлөлт орсны дагуу ажилдаа хэрэгжүүлж ажил олгогч иргэд даатгуулагчдад мэдээлэл өгч ажилласан.	СБХ		
28	№A/16 2	2024.09.26 A/162	Аян зохион байгуулах тухай	Шимтгэлийн өр барагдуулахаар хамралт орлогын байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагуудад авлага барагдуулах чиглэлээр өр авлага үүссэн хугацаа, авлагыг насжилтаар ангилан ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна. 2024 оны эхний авлага 49,339.02 сая төгрөгийн авлагаас 30,864.9 сая төгрөгийг барагдуулж 62,5 хувиар бууруулан ажилласан байна. Албан шаардлага: Тухайн сарын шимтгэлээ сар дамнуулан урсгал авлага үүсгээд байгаа байгууллагуудын удирдлага болон нягтлан бодогчдод урсгал авлага үүсгэхгүй байх тал дээр анхааруулж ажиллаж байна. 90 хүртэл хоногийн насжилттай 17,717.65 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 397 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээр 109 байгууллагын 3,643.68 сая төгрөг барагдуулан ажилласан. Уулзалт: Нийгмийн даатгалын шимтгэлийн 11,208.39 төгрөгийн өртэй 144 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 32 байгууллагын 2,241.27 сая төгрөгийн өр авлагыг барагдуулж ажилласан байна. Данс хаасан: Шимтгэлийн авлага барагдуулахаар арилжааны банкуудад мэдэгдэл хүргүүлснээр 52,362.72 сая төгрөгийн өртэй нийт 4218 ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоож 1198 байгууллагын 18,716.50 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. Авлага барагдуулахаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 7 хоног бүр тогтмол удирдлагад танилцуулга хийж ажиллаж байна.	ХОХ		

				Шүүхэд шилжүүлсэн: Шүүхэд шилжүүлж нэхэмжлэл үүссэн нийт 57 ажил олгогчийн 8,424.6 сая төгрөгийг шүүхэд нэхэмжилснээс 9 ажил олгогчийн бүрэн буюу хэсэгчлэн барагдаж, 1,404.20 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. НШШГГ-т шилжүүлсэн: НШШГГ-т шилжүүлсэн нийт 49 ажил олгогчийн 2,890 сая төгрөгийн өр үүссэнийг НШШГГ-т шилжүүлснээр 91.10 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна.			
ДӨРӨВ. НДҮЗ ТОГТООЛ							
29	№ 09	2023.12.04 Дугаар 09	Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг судлан байцаагч, ажилтнуудыг арга зүйгээр хангаж, ажил олгогчдын захирал нягтлан, даатгуулагчдад сургалт зохион байгуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллээр ханган ажилласан.	ХОХ		
30	№ 20	2023.12.21 Дугаар 20	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай	Өндөр насны тэтгэврийг нэрийн дансны аргаар бодохдоо эрэгтэй хүнийг 15 жилээр, эмэгтэй хүний насыг 22 жил байхаар тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тогтоосны дагуу мөрдөж хэрэгжүүлж байна.	ТТХ		
31	№ 10	2023.12.04 Дугаар 10	Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай	Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийг оны турш 30 даатгуулагчийн 7,086,000 төгрөгийн төлбөрийг олгосон байна.	ТТХ		
32	№ 15	2023.12.21 Дугаар 15	Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөс баталсан “Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 15 дугаар тогтоолын дагуу даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 14.3 хувиар баталсныг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээний талаарх мэдээллийг иргэд, даатгуулагчдад хүргэх, мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллалаа.	ТТХ		

33	№01	2024.03.05 Дугаар 01	Журам батлах тухай	Захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдээгүй байгаа.			
Хэсгийн дундаж хувь							
ТАВ. НДЕГ-ЫН ДАРГЫН ТУШААЛ							
34	№А/19 0	2023.12.27 А/190	Журам батлах тухай	2023 оны “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх бүртгэх, хөтлөх шилжүүлэх” А/190 дугаар журмын дагуу 910 ажил олгогчийн 3627 даатгуулагчийн бүртгэх ажлыг хийсэн болно.	ХОХ		
35	№А/43	2024.04.02 А/43	Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай	Ажил олгогчтой байгуулсан Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа иргэний уг гэрээгээр тохирсон ажлын хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн кодыг “02” гэж тогтоосноор тооцон нийгмийн даатгалын шимтгэл төлүүлж, “06” кодын нэрийг “Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх /эцэг/” гэж, “32” кодыг “Хууль бусаар ажлаас халагдсан ажилтан” гэж тус тус өөрчилснөөр хэрэгжүүлэн ажиллаж байна.	ХОХ		
36	№А/61	2024.04.24 А/61	2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор” Тайлант хугацаанд нийгмийн даатгалд шинээр 910 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээж авч тооцоог тухай бүр хийж, албан журмын даатгалд 3627 даатгуулагчийг хамруулан ажиллаж байна.	ХОХ		
37	№А/79	2024.05.17 А/79	Болзолт уралдаан зарлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор 2024.05.17-ны №А/79 “Болзолт уралдаан” зарласан 2024.05.29-ний өдөр “Хамралтыг нэмэгдүүлэх” ажил эрчимжүүлэх аян зарлаж БГДНДГ-ын даргын баталсан тушаалаар төлөвлөгөө боловсруулан дараах ажлууд хийгдсэн..	ХОХ		

				• "Тайлант хугацаанд нийгмийн даатгалд шинээр 910 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээн авч тооцоог тухай бүр хийж, албан журмын даатгалд 3627 даатгуулагчийг хамруулан ажиллаж байна. • Тухайн онд сайн дурын даатгалд гэрээ сунгалт болон шинээр бүртгүүлсэн 4085 даатгуулагч гэрээ байгуулсан. Үүнээс энгийн сайн дурын даатгалд 3615, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эцэг эх-221, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх-234, малчнаар 15 даатгуулагчийг тус тус хамруулсан. • 2024 оны жилийн эцсийн байдлаар программд бүртгэлтэй 16,595 сайн дурын даатгуулагч байна. Болзолт уралдааны хүрээнд зах худалдааны төвүүдэд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд Номин их дэлгүүр, E-mart худалдааны төв, Хархорин худалдааны төвүүдэд очиж ажилласан. "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил"-ийн хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлах, мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхжүүлэх зорилгоор 09 дүгээр сарыг "Нээлттэй мэдээллийн сар" болгон зарласан. Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн талаарх тараах материалыг 450 гаруй иргэд, даатгуулагчдад тараан таниулсан. Тухайн өдрийн үйл ажиллагааг Монголын Үндэсний Олон Нийтийн Радио телевизийн "Цагийн хүрд" болон UBS телевиз "CITY NEWS" мэдээллийн хөтөлбөрөөр мэдээ бэлтгэн улс орон даяар дамжуулан ажилласан.			
38	№ A/83	2024.05.21 A/83	Маягтын загвар батлах тухай	НДЕГ-ын даргын 2024.05.28-ны өдрийн А/83 тоот тушаалаар батлагдсан дансны зарлагын гүйлгээ түр зогсоох маягтын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахаар арилжааны банкуудад мэдэгдэл хүргүүлснээр 52,362.72 сая төгрөгийн өртэй, нийт 4218 ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоож, 1198	ХОХ		

				байгууллагын 18,716.50 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна.			
39	№139	2024.08.07 А/139	Ажлын цаг ашиглалт, бүтээмж, хариуцлагыг сайжруулах тухай	Албан хаагч, ажилтнуудын ажлын хариуцлага, дэг журмыг бэхжүүлж, ажлын бүтээмж, цаг ашиглалтад тавих хяналтыг сайжруулж ажилтнуудын цаг бүртгэлийг ЭЙБЛ системээр бүртгэж, сар бүр цаг бүртгэлийн тайлан гаргаж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 120 минутаас дээш хоцролттой ажилтнуудад мэдэгдэл хүргүүлж ажилласан.	ЗХХ		

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА:
ТАНИЛЦСАН:
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ОДМАА

Ц.ХАНДСҮРЭН

Л.ОЧИРБАЛ